*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН АЛСЫН ЗАЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.САНСАРМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Алсын зайн технологийн бодлогын удирдамж, нэгдсэн зохицуулалтаар хангах үйл ажиллагааны төлөвлөлт хийх** | | | | | | | |
| 1 | ***Арга хэмжээ: 1.1*** **МУХТЖҮЧ-2.2.3** **ЗГҮАХ 2.3.2.6.415** Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ыг хөгжүүлэх | Телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 250 | 260 | - Орон нутгийн иргэд нарийн мэргэжлийн эмчийн дүгнэлтийг оршин суугаа орон нутагтаа авах боломжийг бүрдүүлж Улаанбаатар хотын лавлагаа шатлалын эмнэлгүүдийн ачаалал, чирэгдлийг бууруулах зорилготой “Зайн оношилгооны төв”-ийг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэд байгуулагдсан.<br>- 2025 оны 3 дугаар сараас УХТЭ-ийн харьяанд шилжүүлсэн. 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагууд өөрийн эмнэлэг дээрх дүрс оношилгооны хариуг нэгдсэн PASC системийн тусламжтайгаар зайн оношилгооны төв рүү илгээж, зөвлөмж дүгнэлтийг авч байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар нийт 2098 дүрс оношилгоо хариу дүгнэлт хийж, зөвлөгөө зөвлөмж өгөгдсөн байна. | 1-12 | 100% |

$\frac{650-250}{260-250} \cdot 100\% = \frac{-190}{10} = -10$

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Зүрх судасны салбар дахь телемедины (mnCardio) програм ашиглагдаж байгаа бөгөөд 2025 оны 5 сарын 31 байдлаар 331,385 иргэний мэдээлэл бүртгэгдэж, 444,495 эмчийн үзлэг, 2,660 ЭХО үзлэг хийгдэж, 5,453 хэлэлцүүлэг, 10,823 зөвлөгөөн, 71174 иргэнд ЗСӨ-ний ойрын 10 жилийн эрсдэлийн үнэлгээ хийгдсэн. 2025 онд тус программд 60 эрүүл мэндийн байгууллагыг холбоод байна. | | |
| 2 | ***Арга хэмжээ: 1.2***<br>**ЗГҮАХ 2.3.2.6**<br>Алсын зайн оношилгооны тусламж үйлчилгээний журам боловсруулж, батлуулах | Батлагдсан журам | ЭМС-ын 2013 оны 330 дугаар тушаал | Журам шинэчлэн боловсруулсан байна | ЭМС-ын 2013 оны 09 сарын 11-ны өдрийн 330 дугаар тушаалаар “Телемедициний үйлчилгээний ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж, 7 бүлэгтэй журмыг төслийн боловсруулсан бөгөөд ЭМС-ын тушаалаар батлуулахад бэлэн болсон. | 3-12 | 90%<br>80x60/100=54 |
| 3 | ***Арга хэмжээ: 1.3***<br>Зайн оношилгооны төвийн (дүрс оношилгоо) үйл ажиллагааны журмын батлуулж хэрэгжүүлэх | Батлагдсан журам | - | Журам боловсруулсан байна | Зайн оношилгооны төвийн (дүрс оношилгоо) үйл ажиллагааны журмын төсөл боловсруулж, ЭМС-ын тушаалаар батлуулахад бэлэн болсон.<br>21 аймгийн дүрс оношилгооны тоног төхөөрөмжийн (КТ, MRI, ангиографийн аппарат, эхо аппарат) судалгаа авч нэгтгэн, радиологийн нийгэмлэгт танилцуулсан. | 1-12 | 90% |
| | | ЗОТ-өөр тусламж үйлчилгээ авсан хүний тоо | - | 300 | Зайн оношилгооны төвөөр нийт 2098 дүрс оношилгоо хариу дүгнэлт хийж, зөвлөгөө зөвлөмж өгснөөс 1878 КТ шинжилгээ, 220 рентген шинжилгээ байна. | 100 | 95 |
| 4 | ***Арга хэмжээ: 1.3.***<br>“Цахим эрүүл мэнд” цогц арга хэмжээний төлөвлөгөөний боловсруулж, батлуулах | Батлагдсан төлөвлөгөө | - | Цогц арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна. | - “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж, ЦХИХХЯам, БЯ, ЭМХТ, ЭМДЕГ болон бусад холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж санал авсан.<br>- 2025.04.10-11-ны өдрүүдэд ЦХИХХЯамтай хамтран “Цахим эрүүл мэнд” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, төлөвлөгөөний төслийн эцсийн | 1-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлгийн хийж, холбогдох өөрчлөлтүүдийг хийсэн.<br>- Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/201, А/81 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан. Уг төлөвлөгөөр 10 зорилтын хүрээнд 62 үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. | | |
| **Зорилт 2. Алсын зайн технологийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалт хийх** | | | | | | | |
| 5 | ***Арга хэмжээ: 2.1.***<br>Алсын зайн технологийн нөхцөл байдлын үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээ хийх удирдамж батлагдсан байна. | - Алсын зайн технологийн нөхцөл байдлын үнэлгээ хийх удирдамжийг боловсруулан батлуулахад бэлэн болсон. Уг удирдамжийн дагуу үнэлгээг 7 чиглэлээр хийгдэнэ. Үүнд: Хууль, бодлого, зохицуулалт, технологийн дэд бүтэц, хүний нөөц, үйлчилгээний хүртээмж, санхүүжилт, тогтвортой байдал, өгөгдөл, аюулгүй байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамж.<br>- Тус ажлыг хийхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>- ДЭМБ-ын суурин төлөөлөгч болон холбогдох мэргэжилтнүүд танилцуулсан.<br>- 2025.04.04-ны өдөр СТГ-ын дарга, ЭММЦХХэлтэс Люксембургийн хөгжлийн агентлагын төлөөлөгч Timothee Wagner, Peter Heimann, MOH007 төслийн зөвлөх Д.Мөнгөнчимэг, Э.Өнөрөө нартай уулзалт зохион байгуулж, шинэ төслийг цахим эрүүл мэндийн чиглэлд хэрэгжүүлэх тухай санал солилцсон. | 6-12 | 90% |
| 6 | ***Арга хэмжээ: 2.2.***<br>Алсын зайн технологийг өргөжүүлэхэд шаардлагатай тоног | Судалгааны тайлан | - | Судалгаа асуумж батлагдаж, мэдээлэл цуглуулсан | - Алсын зайн технологийг өргөжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааны асуумж боловсруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, мэдээлэл цуглуулж байна. | 6-12 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмжийн судалгаа хийх | | | батлагдсан байна. | - 21 аймаг, 9 дүүргээс судалгаа ирүүлэх тухай албан бичиг төлөвлөсөн боловч яамнаас албан бичиг яваагүй. ЭМХТөвөөс бичиг явуулж, судалгааг нэгтгэсэн. Эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж (амьсгалын аппарат болон өвчтний хяналтын монитор) нийлүүлэгч компаний (GE- Интерсайнс ХХК, Mindray - Биомед трейд ХХК, Drager - Сетунари ХХК, Aeonmed, Biocare, Prunus - Сүвэн Уул ХХК, Comen, Contec - Медимпекс интернейшнл ХХК) төлөөлөл болон Аксис системс ХХК, ЭММЦХХэлтэстэй хамтарсан уулзалт зохион байгуулж, тоног төхөөрөмжийн холболтын талаар мэдээлэл солилцсон. | | |
| 7 | ***Арга хэмжээ: 2.3.***<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй цахим технологийн хөрөнгө оруулалтын замын зураглал гаргах | Зураглал хийгдсэн байна | - | Удирдамж, арга аргачлал боловсруулсан байна. | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй цахим технологийн хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн шийдвэрлэсэн 5 тушаал (нийт – 3,6 тэрбум төгрөг) боловсруулан батлуулсан. Үүнд:<br>1. ЭМС-ын 2025.03.07-ны өдрийн А/67 дугаар тушаалаар Глобаль сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх "Халдварт өвчний тандалтын цахим програм хөгжүүлэх" арга хэмжээний жагсаалт, төсвийг (2,7 тэрбум) батлуулж, ЭМХТөвд эрх шилжүүлсэн.<br>2. ЭМС-ын 2025.04.02-ны өдрийн А/104 дугаар тушаалаар сайдын багцын хөрөнгөөр хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах" журмын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн цахимжилтыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээний жагсаалт, төсвийг | 6-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (396.0 сая төгрөг) батлуулж, ЭМХТөвд эрх шилжүүлсэн.<br>3. ЭМС-ын 2025.05.06-ны өдрийн А/187 дугаар тушаалаар сайдын багцын хөрөнгөөр хэрэгжүүлэх "Зайнаас дүрс оношилгооны зөвлөгөө өгөх, дүгнэлт бичих төвлөрсөн PACS системийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг (75.0 сая төгрөг) батлуулж, УХТЭ-т эрх шилжүүлсэн.<br>4. ЭМС-ын 2025.05.07-ны өдрийн А/190 дугаар тушаалаар сайдын багцын хөрөнгөөр хэрэгжүүлэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж, санхүү нөөц бүртгэлийн системийн процессыг оновчтой, үр ашигтайгаар зохион байгуулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, цахимжуулалтыг эрчимжүүлэхэд шаардлагатай төсвийг (300.0 сая төгрөг) батлуулж, УНТЭ-т эрх шилжүүлсэн. УНТЭ-т 4/2536 дугаар албан бичгээр тушаалыг хүргүүлсэн.<br>5. ЭМС-ын 2025.05.26-ны өдрийн А/205 дугаар тушаалаар сайдын багцын хөрөнгөөр хэрэгжүүлэх Үйлчлүүлэгчийн цаг захиалгын систем хөгжүүлэхэд шаардлагатай төсвийг (150.0 сая төгрөг) батлуулж, ЭМХТ-т эрх шилжүүлсэн. УНТЭ-т 4/2794 дугаар албан бичгээр тушаалыг хүргүүлсэн. | | |
| **Зорилт 3. Алсын зайн технологийн сургалтын төлөвлөлт хийх** | | | | | | | |
| 8 | ***Арга хэмжээ: 3.1.***<br>Алсын зайн оношилгооны технологийн чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | - | 100 | - Snomed гишүүнчлэлийн төлбөрийг (4,413.50 USD) Санхүү, даатгалын хэлтсийн даргад танилцуулж, шийдвэрлүүлснээр 2025.04.24-нд Монгол улс албан ёсны гишүүн болсон. Гишүүнчлэлтэй болсноор snomed олон | 1-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | улсын ангилал системийн талаарх сургалтууд хийгдэнэ.<br>- Азийн цахим эрүүл мэндийн мэдээллийн холбооны Ажлын Зөвлөлийн гишүүнд ЭМЯ-ны ЭММЦХХ-ийн дарга Э.Мягмар-Өлзийг нэр дэвшүүлсэн албан захидлыг 2/82 дугаар албан тоотоор хүргүүлсэн.<br>- Хан-Уул дүүргийн 25 хорооны ӨЭМТ-ийн эмч нарт зориулсан сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, сургалтад 70 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 70/100 = 70x60/100 = 42.<br>90% | |
| **Зорилт 4. Хариуцсан асуудлаарх стратегийн эрсдлийг тодорхойлох, эрсдлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, батлуулах үйл ажиллагааны төлөвлөлт хийх** | | | | | | | |
| 9 | ***Арга хэмжээ: 4.1.***<br>Алсын зайн оношилгооны технологийн чиглэлээр эрсдлийн үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | - | Алсын зайн технологийн нөхцөл байдлын үнэлгээ хийх удирдамжийн дагуу алсын зайн оношилгооны технологийн чиглэлээр эрсдлийн үнэлгээ хийгдэнэ. Санхүүжилтийн асуудал хүлээгдэж байна. | 9-12 | 80% |
| **Зорилт 5. Хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт хийх** | | | | | | | |
| 10 | ***Арга хэмжээ: 5.1***<br>**ЗГҮАХ 2.3.2.6**<br>"Цахим эмнэлэг"-ийн (Online hospital) үйл ажиллагааг туршилтаар нэвтрүүлэх | Эрүүл мэндийн байгууллагын тоо | - | 25 | - "Цахим эмнэлэг" байгуулах ажлын эхлэл өрхийн эрүүл мэндийн төвөөс шаардлагатай иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн эхний үзлэг болон шинжилгээний цаг товлох үйлчилгээг цахимаар хийж нэвтрүүлэх ажлыг 2025.01.08-ны өдрөөс Хан-Уул дүүргийн ӨЭМТөвөөс туршиж эхлүүлэх ажлыг эхлүүлсэн.<br>- Цахим эмнэлгээр үйлчилгээ үзүүлэх зураглалыг гаргасан.<br>- "Цахим эмнэлэг"-ийн үйл ажиллагааг туршилтаар зохион байгуулах" тухай журмын төсөл боловсруулсан.<br>- 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4147 цахим үзлэг хийгдсэн. | 1-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | ***Арга хэмжээ: 5.2***<br>Өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад буй иргэдэд “Зүүдэг төхөөрөмж” зэрэг эрүүл мэндийн хяналтын төхөөрөмжийг туршилтаар нэвтрүүлэх | Хяналтын төхөөрөмжийг ашиглаж буй иргэдийн тоо | - | 2 | - Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хиймэл оюун ухаан (artificial intelligence) бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж болон зүүсгэл технологи (wearable technology) нэвтрүүлэх зорилгоор судалгаа мэдээлэл авах тухай 2/2461 тоот албан бичгийг Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч байгууллагын дарга, захирал нарт хүргүүлэв<br>- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад буй иргэдэд “Зүүдэг төхөөрөмж” зэрэг эрүүл мэндийн хяналтын төхөөрөмжийг туршилтаар нэвтрүүлэхээр судалгаа хийгдэж байна. | 1-12 | 80%<br>50% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Чиг үүрэг болон мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалт, семинарт оролцох | Сургалт, семинарын тоо | - | 2 | 1. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл 2.0 сэдэвт сургалт – 2025.01.31<br>2. “Их өгөгдөл, хиймэл оюуны чуулган уулзалт (Data +Ai) 2025” чуулга уулзалт – 2025.02.13<br>3. Эрүүл мэндийн салбарын цахимжилт ба хүний эрх – хэлэлцүүлэг – 2025.02.26<br>4. Цахим эрүүл мэнд – уулзалт хэлэлцүүлэг – 2025.04.10-11<br>5. Tech4health 2025 – ЭМСалбарын дижитал шилжилт – хэлэлцүүлэг - 2025.04.16<br>6. Яаралтай тусламжийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх нь (Emergency medical system) семинар - 2025.05.09 | 1-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 2. Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх | Хэлний түвшин | B1 түвшин | Сургалтад хамрагдсан байна | - Pre-IELTS -ийн 3 сарын сургалтад хамрагдаж байна. 2025.07.28-нд дуусна.<br>- KOFIH (БНСУ-ын Олон улсын эрүүл мэндийн сан)-ийн EE Jong-wook-ийн тэтгэлэгт "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер"-ийн магистрын сургалтад хамрагдахаар сонгон шалгаруулалтад тэнцсэн. 2025.09.01-нээс сургалтад хамрагдана. | 3-12 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Алсын зайн технологийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
*( Албан тушаал )*

Б.Сансармаа / ............................ /
*( Нэр, гарын үсэг )*

2025.06.18
*( Огноо )*